



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2021/06

<http://www.ubstat.mn>



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2021 ОН	2
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	3
 НИЙГМИЙН ДААТГАЛ	4
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	8
 ТОХИЖИЛТ	9
 ГЭМТ ХЭРЭГ	11
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	13
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	17
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	20
 ГАЗАР ТАРИАЛАН	21
 ТЭЭВЭР	21
 АЖ ҮЙЛДВЭР	22
 ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	25

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	180 789	189 248	197 935
Шинээр төрсөн хүүхэд	тоо	2 229	2 330	2 446
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	618	554	478
үүнээс: эмэгтэй	хүн	337	287	235
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1 268	564	12 614
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	1 176	895	891
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	1.4	0.4	0.9
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	2 657.8	2 816.0	2 849.1
Дүүргийн төсвийн орлого	сая төгрөг	46 123.5	52 160.3	90 226.5
Дүүргийн төсвийн зарлага	сая төгрөг	38 197.4	48 852.4	51 777.5



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2021 оны 6 дугаар сард 478 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 76 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 49.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

2021 оны 6 дугаар сард орон тооны цомхотголоор 19, байгууллага татан буугдсанаас 5, мэргэжил, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 7, өөр газраас шилжиж ирсэн 14, сургууль төгссөн 12, бусад шалтгаанаар 190 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 85 хүн ажилд орсноос нөхөрлөл компанид 9, төсөвт байгууллагад 70, бусад газарт 6 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 2. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн 6-р сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2019.VI	2020.VI	2021.VI	2019.VI	2020.VI	2021.VI
Нийт ажилгүйчүүд	618	554	478	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	326	255	205	52.8	46.0	42.9
Тусгай дунд боловсролтой	24	24	19	3.9	4.3	4.0
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	21	20	18	3.4	3.6	3.8
Бүрэн дунд боловсролтой	222	235	209	35.9	42.4	43.7
Бүрэн бус дунд боловсролтой	15	13	22	2.4	2.4	4.6
Бага, боловсролгүй	10	7	5	1.6	1.3	1.0

Зураг 1. Ажилгүйчүүд насны бүлгээр, 2021.VI сард



2021 оны 6 дугаар сард 247 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл 43.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 59 (12.4%) нь 15-24 насны, 200 (41.8%) нь 25-34 насны, 138 (28.9%) нь 35-44 насны, 81 (16.9%) нь 45-60 насны хүмүүс байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны эхний 6 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 4423 байгууллагын нийт 108.7 мянга гаруй хүн хамрагдаж шимтгэл төлсөн ба тэдгээрийн 74.9 мянга (69.0%) нь ААНБ-ын, 11.2 мянга (10.3%) нь төсвийн байгууллагын, 7.6 мянга (6.9%) нь сайн дурын даатгуулагчид, 15.0 мянга (13.8%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт/ Бууралт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	4 107	4 423	316	7.7
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	3 988	4 301	313	7.8
Төсөвт байгууллагын тоо	119	122	3	2.5
Нийт даатгуулагчдын тоо	108 768	108 704	-64	-0.1
ААНБ-ын даатгуулагчийн тоо	75 239	74 981	-258	-0.3
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	10 585	11 201	616	5.8
Сайн дурын даатгуулагчийн тоо	7 519	7 561	42	0.6
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	15 425	14 961	-464	-3.0

2021 оны эхний 6 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 123.6 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 8.0 тэрбум төгрөгөөр (6.9%) илүү бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, 2021 оны эхний хагас жилд

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2020 I-VI	2021 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	66 014.6	80688.6	56 355.5	94 783.3	85.4	117.5
Тэтгэмжийн сангийн орлого	6 641.7	5 955.5	7 242.5	3 362.7	27.6	56.5
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	5 879.8	5 944.9	6 778.0	3 020.1	115.3	50.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1 309.3	1200.6	1 479.5	642.1	113.0	53.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	15 750.5	21 764.4	15 750.5	21 764.4	100.0	100.0
Нийт	95 595.9	115 554.0	87 606.0	123 572.6	76.0	106.9


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 76.7 хувь нь тэтгэврийн даатгалын сангийн, 2.7 хувь нь тэтгэмжийн даатгалын сангийн, 2.5 хувь нь ҮОМШӨ-ний даатгалын сангийн, 0.5 хувь нь ажилгүйдлийн даатгалын сангийн, 17.6 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 3. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 17050 хүнд 50.0 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3240 хүнд 6.6 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 827 хүнд 1.7 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1250 хүнд 5.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 4433 хүнд 967.4 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 3014 хүнд 6.1 тэрбум төгрөгийг, 42 хүнд оршуулгын тэтгэмж 42.0 сая төгрөгийг тус тус олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 159 хүнд 512.9 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 19 хүнд 80.2 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 32 хүнд 46.4 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувиллын зардал 1 хүнд 0.4 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1233 хүнд 3.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 66.2 хувийг тэтгэврийн, 12.9 хувийг тэтгэмжийн, 1.9 хувийг ҮОМШӨ-ний, 3.9 хувийг ажилгүйдлийн, 15.1 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 4. Даатгалын сангийн орлого, зарлага сая,төг



Зураг 5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо





НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 6 сард нийгмийн халамжийн сангийн нийт 51.2 хувь нь нийгмийн халамжийн сан, 3.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 3.3 хувь нь хүнс тэжээл хөтөлбөр, 8.9 хувь нь алдарт эхийн одонгийн тусламж, 10.5 хувь нь насны хишиг, 20.7 хувь нь цалинтай ээж, 1.7 хувь нь өрх толгойлсон эцэг эхэд тэтгэмж хөтөлбөрт, 0.1 хувь нь хүүгийн болон бусад орлогод тус тус

хуваарилсан байна.

Харин зарлагын 51.2 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 13218 хүнд, 9922 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 38 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 15366 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2021 оны VI сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	13 686.4	
А. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	13 670.9	
1) Нийгмийн халамжийн сан	7 009.4	
2) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	477.4	
3) хүнс тэжээл хөтөлбөр	459.4	
4) алдарт эхийн одонгийн тусламж	1 216.5	
5) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	0.0	
6) насны хишиг	1437.7	
7) цалинтай ээж хөтөлбөр	2 831.2	
8) өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	232.1	
9) онцгой тохиолдолд олгох тэтгэмж	7.2	
Б. Хүүгийн болон бусад орлого	15.5	
а) хүүгийн орлого	10.1	
б) бусад орлого	5.4	
Зарлагын нийт дүн	13 693.3	56 741
1. Нийгмийн халамжийн сан	7 019.1	13 218
2. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3 544.1	15 366
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1 219.1	9 922
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	4.5	38
5. Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	459.2	9 251
6. Насны хишиг	1440.1	8 940
7. Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	7.2	6




ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 6 сард 12614 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 12050 хүнээр (22.3 дахин), 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 630.9 продицимилээр нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 98.9 хувийг ковид 19, 0.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 0.1 хувийг тэмбүү, 0.1 хувийг трихомониаз, 0.2 хувийг заг хүйтэн, 0.1 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 12478 (98.9%)-өөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.


Хүснэгт 6. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт, бууралт 2021/2020	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	564 31.0	12614 661.9	12050 630.9	22.3 дах
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	10 0.5	1 0.1	-9 -0.4	-90.0
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	90 4.9	1 0.1	-89 -4.8	-98.9
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	10 0.5	-	-10.0 -0.5	-100.0
Сальмонеллөз	Бодит тоо 10000 хүнд	11 0.6	-	-11 -0.6	-100.0
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	119 6.5	-	-119 -6.5	-100.0
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	-	-2 -0.1	-100.0
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	-	-2 -0.1	100.0
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	16 0.9	1 0.1	-15 -0.8	-93.7
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	88 4.8	17 0.9	-71 -3.9	-80.7
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	21 1.2	19 1.0	-2 -0.2	-9.5
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	20 1.1	16 0.8	-4 -0.3	-20.0
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	129 7.4	76 4.0	-53 -3.4	-41.1
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	- -	2 0.1	2 0.1	0.0
Ковид 19	Бодит тоо 10000 хүнд	24 1.3	12478 654.7	12454 653.4	519.9 дах
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	22 1.2	3 0.2	-19 -1.0	86.4

Зураг 6. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2021 оны эхний 6 сард эхийн эндэгдэл 4 болж, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 хүүхдээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021}{2020} \%$
Амаржсан эхийн тоо	2 206	2 310	2 420	4.8
Амьд төрсөн хүүхэд	2 229	2 330	2 446	5.0
Төрөхийн улмаас эндсэн эх	-	-	4	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	13	15	15	-
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	2	100.0

*Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 6 дугаар сард дунджаар 14.8°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.2°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал -1.8°C -аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 32.2°C , хамгийн хүйтэн хэм -1.1°C , хур тунадасны нийлбэр 83.5 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 18 метр секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 өдөр байна.

Хүснэгт 8. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$, VI сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.050	369	0.045	-	0.011
Азотын давхар исэл	NO_2	0.050	304	0.054	5	0.024
Тоосжилт	PM_{10}	0.100	392	0.228	26	0.044
	$\text{PM}_{2.5}$	0.050	249	0.048	-	0.010
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	1 045	3.046	-	0.370
Озон	O_3	0.100	600	0.096	-	0.044

¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж

Хүснэгт 9. Хан-Уул дүүргийн агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, VI сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл – экспо төв			Нисэх		
		2019	2020	2021	2019	2020	2021
		Мг/м ³					
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.005	0.009	0.012	0.002	0.005	0.020
	Хамгийн их	0.0012	0.029	0.036	0.005	0.010	0.036
	ХХХ*-с давсан хувь	-	0.0	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	29	30	27	30	28	23
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	-	0.030	0.015	-	0.015
	Хамгийн их	-	-	0.044	0.023	-	0.030
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	28	30	-	27
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Дундаж	-	-	-	-	-	0.238
	Хамгийн их	-	-	-	-	-	0.801
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	-	-	80
Тоос PM ₁₀	Дундаж	0.030	0.072	0.049	0.093	0.093	0.025
	Хамгийн их	0.128	0.174	0.130	0.175	0.208	0.065
	ХХХ*-с давсан хувь	3.0	26.0	4.0	53.0	43.0	-
	Хэмжилтийн тоо	29	31	27	30	28	18
Тоос PM _{2.5}	Дундаж	-	-	-	0.016	0.017	0.006
	Хамгийн их	-	-	-	0.027	0.030	0.014
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	0.0	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	30	28	18
Озон O ₃	Дундаж	0.034	0.021	-	0.043	-	0.057
	Хамгийн их	0.066	0.041	-	0.071	-	0.096
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	90	80	-	81	-	80

• -Хүлцэх хэм хэмжээ **- CO, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон
Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны 6-р сарын танилцуулга

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны 6 дугаар сарын 23, 24-ний өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд эрдэс фосфор 14.8 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.7 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2021 оны 2-р улиралд дүүргийн тохижилт үйлчилгээний ажилд шинээр 275822 ширхэг нэг наст ургамал тарьж, 2546.7 м² цэцгийн мандалыг байгуулсан. 3400 мян.м² зүлэгжүүлжүүлсэн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж, 9700 мян.м² зүлэгжүүлсэн талбайг арчилж тордох бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэжээ.

Хүснэгт 10. Шинээр тарьсан, арчилж тордсон мод, сөөг

Үзүүлэлт	хэмжих нэгж	Гүйцэтгэл	
		тоо хэмжээ	зарцуулсан хөрөнгө /мян.төг/
Шинээр тарьсан нэг наст ургамал	ширхэг	275 822	41 373.3
Хотын нийтийн эзэмшилд	ширхэг	103 000	15 450.0
Орон сууцны хороололд	ширхэг	26 000	3 900.0
Албан газрын орчинд	ширхэг	9 730	1 459.5
Парк цэцэрлэгт	ширхэг	137 092	20 563.8
Байгуулсан цэцгийн мандал	м ²	2 546.7	2 546.7
Хотын нийтийн эзэмшилд	м ²	897.5	897.5
Орон сууцны хороололд	м ²	216.6	216.6
Албан газрын орчинд	м ²	161.0	161.0
Парк цэцэрлэгт	м ²	1 271.6	1 271.6
Нөхөн зүлэгжүүлсэн талбай	мян м ²	3 400	85 000.0
Хотын нийтийн эзэмшилд	мян м ²	3 400	85 000.0
Орон сууцны хороололд	мян м ²	-	-
Албан газрын орчинд	мян м ²	-	-
Парк цэцэрлэгт	мян м ²	-	-
Арчилж тордсон	мян м ²	9 700	116 400
Зүлэг	мян м ²	9 700	116 400
Цэцэрлэгжүүлсэн талбай	мян м ²	-	-

Дүүргийн тохижилт үйлчилгээний ажилд 2648 ширхэг мод, 22027 ширхэг сөөг шинээр тарьж, 29535 ширхэг сөөг, модыг нөхөн тарьж, 2625 ширхэг мод, 5832 ширхэг сөөгийг арчилж тордох зэргээр бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 11. Хог цэвэрлэгээний ажил, зарцуулсан хөрөнгө, 2021 оны эхний хагас жилд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Зарцуулсан хөрөнгө	
		2020	2021	2020	2021
Цэвэрлэсэн зам талбай	мян м ²	1 877 800.0	5 373 960.0	93 890.0	268 747.5
Тээвэрлэсэн хог	тн	43 833.8	62 431.8	1 832 718.1	1 676 844.1
Үүнээс: Орон сууцнаас	тн	11 986.9	25 582.0	478 996.5	632 683.0
Гэр хорооллоос	тн	9 841.7	26 502.0	393 275.1	722 997.9
ААНБ-аас	тн	8 056.8	9 581.0	321 950.3	301 741.0
Зам талбайгаас	тн	1 724.4	731.0	150 028.2	19 420.6
Хур хог	тн	12 224.0	35.8	488 471.0	1 574

2021 оны эхний хагас жилд дүүргийн хэмжээнд нийт 268747.5 мян.м² талбайг цэвэрлэж, 1676844.1 тонн хог хаягдлыг тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал цэвэрлэсэн зам талбай 186.2 хувиар өсөж, тээвэрлэсэн хог 8.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 12. Шинээр тарьсан, арчилж тордсон мод, сөөг


Үзүүлэлт	хэмжих нэгж	Гүйцэтгэл	
		тоо хэмжээ	зарцуулсан хөрөнгө /мян.төг/
Шинээр тарьсан мод, бүгд	ширхэг	2 648	333 943.0
Хотын нийтийн эзэмшилд	ширхэг	2 172	325 800.0
Орон сууцны хороололд	ширхэг	55	825.0
Албан газрын орчинд	ширхэг	20	100.0
Парк цэцэрлэгт	ширхэг	401	7 218.0
Шинээр тарьсан сөөг, бүгд	ширхэг	22 027	51 267.2
Хотын нийтийн эзэмшилд	ширхэг	41 495.0	41 495.0
Орон сууцны хороололд	ширхэг	4 563.0	4 563.0
Албан газрын орчинд	ширхэг	5 209.2	5 209.2
Парк цэцэрлэгт	-	-	-
Нөхөн тарьсан сөөг, бүгд	ширхэг	29 535	103 372.5
Хотын нийтийн эзэмшилд	ширхэг	29 535	103 372.5
Орон сууцны хороололд	ширхэг	-	-
Албан газрын орчинд	ширхэг	-	-
Парк цэцэрлэгт	ширхэг	-	-
Арчилж тордсон	ширхэг	8 457	14 500
Мод	ширхэг	2 625	7 800
Сөөг	ширхэг	5 832	6 700



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 6 сард 891 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 (0.4%) хэргээр буурсан байна.

Зураг 8. Гэмт хэргийн тоо, жил бүрийн I-VI сард



Нийт гэмт хэргийн 128 (14.4%) нь хулгайн хэрэг, 192 (21.5%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 286 (32.1%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 9 (1.1%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 7 (0.8%) нь хүчингийн хэрэг, 10 (1.1%) нь дээрэмдэх хэрэг, 28 (3.1%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 4 (0.4%) нь хүнийг алах хэрэг, 227 (25.5%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


Хүснэгт 13. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, I-VI сард

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021}{2020} \%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	5	9	80.0	4
Хүчин	9	7	-22.2	-2
Дээрэмдэх	9	10	11.1	1
Хулгай	286	128	-55.2	-158
Залилан мэхлэх	174	286	64.4	112
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	179	192	7.3	13
Малын хулгай	7	-	-	-7
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	-
Хүнийг санаатай алах	7	4	-42.8	-3
ХАБТХАЖЭ*	31	28	-9.7	-3
Бусад	188	227	20.7	39
Бүгд	895	891	-0.4	-4

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт 128 хулгайн гэмт хэргийн 117 (91.4%) нь иргэний өмчийн хулгай, 3 (2.3%) нь авто тээврийн хэрэгслийн хулгай, 8 (6.3%) нь халаасны хулгайн хэрэг эзэлж байна.

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор




Хүснэгт 14. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ**	Бусад
	2020 I-VI	2021 I-VI	Тоо	%							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1	44	40	-4	-9.1	-	1	7	-	1	6	4	-	2	2	10	-	-	1	12
2	71	49	-22	-31.0	-	-	16	-	-	8	7	-	1	2	13	-	-	2	8
3	105	85	-20	-19.0	-	1	14	-	-	10	9	-	1	1	27	-	-	4	28
4	96	78	-18	-18.7	-	2	25	-	-	9	9	-	-	1	24	-	-	2	15
5	14	13	-1	-7.1	-	-	5	-	-	1	1	-	-	1	2	-	-	-	4
6	13	14	1	7.7	1	-	4	-	-	1	1	-	-	-	-	-	-	3	5
7	10	11	1	10.0	-	-	2	-	-	-	-	-	-	-	2	-	-	1	6
8	24	34	10	41.7	-	-	11	-	1	1	1	-	-	1	8	-	-	1	11
9	29	15	-14	-48.3	-	-	9	-	-	1	1	-	-	-	1	-	-	-	4
10	56	28	-28	-50.0	1	-	6	-	1	6	6	-	-	-	7	-	-	2	5
11	113	104	-9	-8.0	-	-	16	-	1	14	12	1	1	-	34	-	-	4	35
12	28	14	-14	-50.0	1	-	7	-	-	2	1	1	-	-	3	-	-	-	1
13	10	13	3	30.0	-	-	10	-	-	-	-	-	-	-	1	-	-	1	1
14	35	16	-19	-54.3	-	1	2	-	-	1	-	1	-	-	6	-	-	1	5
15	115	127	12	10.4	-	1	14	-	1	28	26	-	2	-	49	-	-	4	30
16	42	47	5	11.9	-	2	11	1	1	4	4	-	-	-	13	-	-	1	15
17	17	46	29	2.7*	-	-	7	1	1	8	8	-	-	1	17	-	-	-	12
18	16	23	7	43.7	-	-	3	-	-	9	9	-	-	-	4	-	-	-	7
19	14	60	46	4.3*	-	-	5	-	-	5	4	-	1	-	42	-	-	-	8
20	10	48	38	4.8*	-	1	12	-	-	9	9	-	-	1	14	-	-	-	11
21	33	26	-7	-21.2	1	-	6	-	-	5	5	-	-	-	9	-	-	1	4
Дүн	895	891	-4	-0.4	4	9	192	2	7	128	117	3	8	10	286	-	-	28	227

**ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг


*дахин



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2021 оны эхний 6 сард 90.2 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 16.3 тэрбум төгрөгөөр (15.3%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2020 оноос 73.0 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 36.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.1 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 26.2 хувийг тусламжийн орлого, 35.1 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 10. Төсвийн орлого, зарлага, 2013-2021 онд, сая төг



Татварын орлогын хэмжээ 33.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 2.9 сая төгрөгөөр (8.1%) дутуу бүрдсэн бол, татварын бус орлого 57.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 13.4 тэрбум төгрөгөөр (19.0%) тус тус дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 15. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны эхний VI сард, сая.төг

Төсвийн орлого				Үүнээс:					
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			Зөрүү сая.т
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	90226.5	84.7	-16342.0	33056.4	91.9	-2899.5	57170.1	81.0	-13442.5

Хүснэгт 16. Дүүргийн татварын бус орлого, 2021 оны эхний VI сард, сая.төг

Татварын бус орлого	Үүнээс:								
	Нийтлэг татварын бус орлого			Тусламжийн орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого		
Дүн	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т
57170.1	1844.9	118.2	284.3	23633.0	63.6	-13553.4	31692.2	99.5	-173.2

Орлогын албан татвар төлөвлөснөөс 2.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 22.4 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 5.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 17. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны эхний VI сард, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	106 568.5	90 226.5	84.7	-16 342.0
1.Татварын орлогын дүн	35 955.9	33 056.4	91.9	-2 899.5
1.1 Орлогын албан татвар	23 440.3	26 315.2	112.3	2 874.8
Хувь хүний орлогын албан татвар	23 440.3	26 315.2	112.3	2 874.8
1.2 Хөрөнгийн албан татвар	50.9	28.5	56	-22.4
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	12 464.7	6 712.7	53.9	-5 752.0
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3 864.0	1 808.7	46.8	-2 055.3
Улсын тэмдэгтийн хураамж	2 882.1	1 235.3	42.9	-1 646.7
Ашигт малтмал ашигласны төлбөр	21.9	53.3	243.1	31.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	960	520	54.2	-440.0
1.3.2 Газрын төлбөр	8 600.7	4 887	56.8	-3 713.7
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	17.0	0	17.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0	17.0	0	17.0
2.Татварын бус орлогын дүн	70 612.6	57 170.1	81.0	-13 442.5
2.1 Нийтлэг бус татварын орлого	1 560.7	1 844.9	118.2	284.3
Хүүгийн орлого	0	0	0	0
Торгуулийн орлого	1 200	1 308.8	109.1	108.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	350.6	518.1	147.8	167.5
Бусад орлого	10.1	17.9	178.5	7.9
2.2 Тусламжийн орлого	37 186.4	23 633.0	63.6	-13 553.4
Хандив тусламж /дотоод/	20.5	0	0	-20.5
Төслөөс санхүүжих	37 166.0	23633.0	63.6	-13 533.0
2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	31 865.5	31 692.2	99.5	-173.2
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	31 556.5	31 556.3	100.0	0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	308.9	135.7	54.6	-173.2

*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

Зураг 11. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 12. Татварын бус орлогын бүтэц, хувиар



2021 оны эхний 6 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 51.8 тэрбум төгрөгийн (67.0%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 25.5 тэрбум төгрөгийг (33.0%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 40.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.0 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 31.0 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 24.0 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 18. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2021 оны эхний VI сард, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	90 226.5	77 291.9	51 777.5	67.0	-25 514.4	-38 449.0

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 770.4 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 215.3 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, сарын эцэст нийт 934.3 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 19. Өглөг, 2021 оны эхний VI сард, сая.төг


	06-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	06-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	770.4	215.3	51.4	934.3



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2021 оны 6 дугаар сарын Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2020 оны эцэстэй харьцуулахад 8.4 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1 хувиар, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 13. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 8.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 16.4 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 2.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 22.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 1.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 4.8 хувь, тээвэр бүлгийн үнэ 3.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 0.4 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 0.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 12.7 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 2.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

2021 оны 6 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 24.1 хувийнх нь үнэ өсөж, 4.9 хувийнх нь үнэ буурч, 71.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Хүснэгт 20 . Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020-VI</u> 2019-VI	<u>2021-VI</u> 2020-VI	<u>2021-VI</u> 2020-XII	<u>2021-VI</u> 2021-V
Ерөнхий индекс	102.4	107.1	108.4	100.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	104.2	113.1	116.4	101.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.2	103.1	102.4	100.6
Хувцас, бөс бараа, гутал	104.6	101.6	98.9	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.5	106.1	122.5	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.9	103.1	101.4	100.6
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.1	106.6	104.8	101.4
Тээвэр	92.4	106.9	103.4	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.3	100.3	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	101.3	100.4	100.1
Боловсролын үйлчилгээ	107.0	101.4	100.8	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	108.7	114.1	112.7	104.3
Бусад бараа, үйлчилгээ	104.5	105.9	102.5	100.2

Хүснэгт 21. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**аерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	1.2	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнэ 3.4 хувиар, жимс, жимсгэнийн үнэ 2.7 хувиар, хүнсний ногооны үнэ 2.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дарсны үнэ 2.8 хувиар, шар айрагны үнэ 3.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.2	Хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнийн өсөлтөд хувцас засвар, цэвэрлэгээ, түрээсийн үнэ 0.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.6	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы үнэ 2.8 хувиар, гэр ахуйн барааны үнэ 1.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.4	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 2.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Тээвэр	1.4	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд автомашин, мотоциклын үнэ 4.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд тоглоомын үнэ 2.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	4.3	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гуанз, цайны газрын үнэ 8.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.2	Бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 0.2 хувиар, хувь хүний бусад эд зүйлсийн үнэ 0.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


2021 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Фүжи алим 2700 төгрөг, “Үхрийн мах” ястай 500 төгрөг, “Хонины мах”, ястай 500 төгрөг, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 100 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 150 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 110 төгрөг, Задгай сүү 500 төгрөг, Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК 360 төгрөг, Манжин 250 төгрөг, Байцаа 800 төгрөгөөр тус тус өссөн. “Талх чихэр” ХК-ны “Атар” талх 50 төгрөг, Цагаан будаа 525 төгрөг, Лууван 200 төгрөг, Төмс 200 төгрөг, Элсэн чихэр 250 төгрөгөөр тус тус буурсан.

Хүснэгт 22.Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, төгрөг, жил бүрийн VI сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2020.VI	2021.VI	$\frac{2021}{2020}$ %
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1 300	1 250	96.2
Хонины мах, ястай	Кг	10 500	11 000	104.8
Үхрийн мах, ястай	Кг	12 500	13 000	104.0
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1 550	1 650	106.5
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1 250	1 400	112.0
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	940	1 050	111.7
Элсэн чихэр	Кг	2 700	2 450	90.7
Төмс, монгол	Кг	1 200	1 000	83.3
Байцаа, монгол	Кг	2 000	2 800	140.0
Лууван, монгол	Кг	2 200	2 000	90.9
Манжин, монгол	Кг	2 000	2 250	112.5
Сонгино, хятад	Кг	2 600	2 700	103.8
Цагаан будаа	Кг	3 300	2 775	84.1
Алим, фүжи	Кг	4 900	7 600	155.1
Сүү, задгай	литр	1 700	2 200	129.4
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	2 640	3 000	113.6

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 14. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 15. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 16. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг




Зураг 17. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 23. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020.VI.27					2021.VI.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 260	1 320	1 790	-	-	1 370	1 450	1 990	-
Петровис	1 800	1 350	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Магнай трейд	1 800	-	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Сод монгол	1 800	-	1 400	1 890	-	2 250	1400	1 450	2 290	-
Шунхлай	1 800	-	1 400	1 890	-	2 250	-	1 450	2 290	-
Юнигаз	-	-	-	-	970	-	-	-	-	1 130
Дундаж үнэ	1 800	1 305	1 384	1 870	970	2 250	1 385	1 450	2 230	1 130

*Мэдээллийн эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 6-р сарын мэдээ



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 6 сард 9222 хээлтэгч мал төллөжээ. Нийт гарсан төлөөс 691 (7.5%) нь хорогдож, 8542 (92.5%) төл бойжиж байна.

Хүснэгт 24. Төл бойжилт, төрлөөр, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	9 696	9 222	-	919	2 980	3 050	2 273
Гарсан төл	9 733	9 233	-	919	2 980	3 055	2 279
Үүнээс: Хорогдсон төл	370	691	-	59	43	387	202
Бойжсон төл	9 363	8 542	-	860	2 937	2 668	2 077


Бойжсон нийт төлийн 10.1 хувийг унага, 34.4 хувийг тугал, 31.2 хувийг хурга, 24.3 хувийг ишиг эзэлж байна.


Хүснэгт 25. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	847	2 074	-	238	217	790	829
Үүнээс: өвчнөөр хорогдсон	25	0	-	-	-	-	-
Хорогдсон хээлтэгч	374	728	-	44	79	286	319

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 6 сард 2074 толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1227 толгой малаар өсжээ. Нийт хорогдлын 21.9 хувийг бод мал, 78.1 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 35.1 хувь буюу 728 хээлтэгч мал хорогдсон байна.

Зураг 18. Том малын зүй бус хорогдол, эхний VI сард






ГАЗАР ТАРИАЛАН

2021 оны эхний 6 сард дүүргийн хэмжээнд 11.2 га талбайд төмс, 90.1 га талбайд хүнсний ногоо тариалсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмсний талбай 66.6 хувиар, хүнсний ногооны талбай 12.4 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 26. Тариалсан талбай, жил бүрийн 6 сард

	2020-VI	2021-VI	Өсөлт бууралт /хувиар/
Төмс	33.6	11.2	-66.6
Хүнсний ногоо	102.9	90.1	-12.4
Байцаа	68.9	39.1	-43.3
Лууван	4.0	5.0	25.0
Шар манжин	2.8	9.0	2.2 дах
Улаан манжин	0.7	1.7	242.8
Сонгино	3.6	7.3	202.8
Сармис	0.5	1.5	2 дах
Өргөст хэмх	12.4	12.5	100.8
Улаан лооль	1.8	4.0	222.2
Тарвас	0.0	0.1	-
Амтат гуа	0.0	0.2	-
Хулуу	0.4	1.6	3 дах
Чинжүү	1.1	0.4	-63.6
Бусад	6.6	7.7	116.6

Зураг 19. Тариалсан талбай, жил бүрийн 6 сард




ТЭЭВЭР

Тээвэр, тээвэр зуучлал, агуулахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 2021 оны 2 дугаар улиралд 6718.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1210.9 сая төгрөгөөр (22.0%) өссөн байна.

Хүснэгт 27. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, II улиралд


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 I-VI	2021 I-VI
Нийт орлого	сая.төгрөг	5 507.1	6 718.0
Тээвэрлэсэн ачаа	мян.тн	200.6	11.5
Ачаа эргэлт	мян.т.км	5 387.0	5 373.4



АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2021 оны эхний 6 сард 514.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 694.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 9.4 хувиар, борлуулалт 25.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 20. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2020-2021 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 477.4 тэрбум төгрөгийг дотоодод, 216.9 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 31.2 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 7.5 хувийг хувцас үйлдвэрлэл, 0.5 хувийг үр тариа гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.4 хувийг ундаа үйлдвэрлэл, 1.4 хувийг ээрэх, нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэлт, 90.2 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 21. Үйлдвэрлэлт, 2019-2021 он, тэрбум төг



Зураг 22. Борлуулалт, 2019-2021 он, тэрбум төг



Хүснэгт 28. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021}{2020}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	458.9	19 134.8	41.7*
Металлын хүдэр олборлолт		-	-
Бусад ашигт малтмал олборлолт	458.9	19 134.8	41.7*
Боловсруулах үйлдвэр	401 696.0	426 831.3	106.2
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	192 990.3	295 256.4	153.0
Мах боловсруулах, консервлох	2 834.8	1 619.1	57.1
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	3 062.5	1 732.1	56.5
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	26 273.9	58 970.6	2.2*
Үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	49 571.7	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	22 914.0	17 160.5	74.9
Малын тэжээл үйлдвэрлэл	-	6 976.8	-
Ундаа үйлдвэрлэл	137 905.1	159 225.6	115.5
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	118 395.1	14 944.0	12.6
Хувцас үйлдвэрлэл	23 677.4	42 345.9	178.8
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7 100.7	2 933.2	41.3
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 291.2	16 641.5	2.6
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	10 535.3	6 685.2	63.4
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17 699.5	25 691.4	145.1
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	9 634.5	8 316.2	86.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 267.0	2 133.7	168.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	3 819.5	4 090.5	107.1
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	57.5	1 131.8	19.7*
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	720.0	177.4	24.6
Тавилга үйлдвэрлэл	2 156.3	2 485.7	115.3
Бусад боловсруулах үйлдвэрлэл	4 622.0	424.9	9.2
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	2 729.4	3 573.6	130.9
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	65 265.0	63 239.0	96.9
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2 697.2	4 947.8	183.4
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	215.3	289.6	134.5
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	2 481.9	4 658.2	187.7
ДҮН	470 116.8	514 153.0	109.4

Тайлбар: *дахин

Хүснэгт 29. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021}{2020}\%$	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	436.1	19 134.8	43.9*	90.2
Металлын хүдэр олборлолт	-	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	436.1	19 134.8	43.9*	90.2
Боловсруулах үйлдвэр	486 211.9	606 868.7	124.8	9.8
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	356 948.1	470 072.3	131.7	9.8
Мах боловсруулах, консервлох	8 062.0	4 742.7	58.8	-
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	3 062.5	1 643.1	53.6	-
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	42 960.2	85 090.8	198.1	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	22 949.4	17 254.6	75.2	-
Үр тариа гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	52 924.8	-	0.5
Малын тэжээл үйлдвэрлэл	-	6 976.8	-	-
Ундаа үйлдвэрлэл	279 914.0	301 439.5	107.7	0.4
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	52 599.0	20 991.6	39.9	1.4
Хувцас үйлдвэрлэл	9 395.8	37 732.0	4.0*	7.5
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 600.0	3 096.2	46.9	-
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 291.2	16 641.5	2.6*	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	8 575.3	6 691.5	78.0	-
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17 732.4	25 716.7	145.0	-
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	10 160.1	11 862.8	116.7	-
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 301.1	2 133.7	164.0	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4 428.2	4 191.9	94.7	-
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	57.5	960.3	16.7*	-
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	720.0	175.4	24.3	-
Тавилга үйлдвэрлэл	2 156.3	2 506.3	116.2	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	5 622.6	523.0	9.3	-
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	3 624.0	3 573.6	98.6	-
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	65 265.0	63 239.0	96.9	-
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2 131.2	5 099.8	2.4*	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	215.8	289.6	134.2	-
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	1 915.4	4 810.2	2.5*	-
ДҮН	554 043.9	694 342.4	125.3	-

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2021 оны эхний 6 сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 1077 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 1016 өргөдөл, гомдолд хариу өгч, хугацаа хэтэрсэн 7, шийдвэрлэх хугацаа болоогүй 54 өргөдөл байна.

Хүснэгт 30. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Гомдол	Санал	Талархал	Мэдэгдэл	Хүсэлт					
Удирдлага	5	-	4	-	1	1	-	-	-	4	-	5	-	-	-
ТЗУХ	70	-	54	16	-	15	-	3	-	52	-	55	-	15	-
СТСХ	1	-	1	-	-	-	-	-	-	1	-	1	-	-	-
ТГХХ	32	-	6	3	23	6	3	-	-	23	-	30	-	2	-
НБХ	9	-	7	2	-	1	-	1	-	7	-	9	-	-	-
ТНААХ	148	-	18	83	47	85	14	-	3	46	-	131	-	13	4
ХХҮХ	116	-	103	8	5	5	2	-	-	109	-	114	-	1	1
ХЗАТ	9	-	6	2	1	4	-	-	-	5	-	9	-	-	-
Цэргийн штаб	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын дүн	390	0	199	114	77	117	19	4	3	247	0	354	0	31	5
ХөХҮХ	12	-	5	7	-	6	1	-	-	5	-	12	-	-	-
Газрын алба	280	-	247	22	11	13	3	-	-	264	-	269	-	10	1
Боловсролын хэлтэс	4	-	1	2	1	3	-	-	-	1	-	4	-	-	-
ОБХ	2	-	-	2	-	1	-	-	-	1	-	2	-	-	-
Албан бус- НТБ төв	13	-	13	-	-	-	-	-	-	13	-	13	-	-	-
Бүртгэлийн хэлтэс	16	-	2	13	1	10	2	-	-	4	-	15	-	1	-
ГБХЗХХ	28	-	27	1	-	-	-	1	-	27	-	26	-	2	-
МХХ	240	-	88	144	8	189	2	-	-	49	-	230	-	9	1
Татварын хэлтэс	51	-	48	3	-	2	1	-	-	48	-	51	-	-	-
НДХ	30	-	30	-	-	1	-	-	-	29	-	29	-	1	-
Цагдаагийн газар	11	-	1	7	3	4	-	6	-	1	-	11	-	-	-
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	687	0	462	201	24	229	9	7	-	442	0	662	0	23	2
Нийт дүн	1077	0	661	315	101	346	28	11	3	689	0	1016	0	54	7

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: Мэргэжилтэн Ц.Энх-Оюун



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021 оны эхний 6 сар



Амаржсан эх



2020.I-VI 2 310

2021.I-VI 2 420

Төрсөн хүүхэд



2020.I-VI 2 330

2021.I-VI 2 446



Халдварт өвчнөөр
өвчлөгчид



2020.I-VI 564

2021.I-VI 12 614



Бүртгэгдсэн гэмт хэрэг



2020.I-VI 895

2021.I-VI 891



Бүртгэлтэй ажилгүй иргэд



2020.VI

2021.VI

554

478

♀

287

♀

235



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт

Үйлдвэрлэлт, тэрбум.төг

2020.I-VI 470.1

2021.I-VI 514.1

Борлуулалт, тэрбум.төг

2020.I-VI 554.0

2021.I-VI 694.3



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн
индексийн жилийн өөрчлөлт, хувь

2020.VI 0.4

2021.VI 0.9



Валютын зах
зээлийн ханш

\$

1US\$ = ₮

2020.VI 2 816.0

2021.VI 2 849.1



Дүүргийн төсөв, сая.төг

Орлого

2020.I-VI 52 160.3

2021.I-VI 90 226.5



Зарлага

2020.I-VI 48 852.4

2021.I-VI 51 777.5

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН **мэдээллээ аваарай**

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn